

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/1/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2019 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын захирал
бөгөөд

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70352580 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivanaudit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ.....	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11

2.1. Оршил

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хутаг-өндөр сумын ЭМТ-ийн дарга Б.Туяацэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-өндөр сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 01-нээс 2020 оны 03 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван аудит ХХК Орхон салбарын аудитор Б.Пүрэвсүрэн /Булган аймгийн төрийн аудитын газрын захиалгаар/ хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Далайван аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдагдалгүй түргэн шуурхай хүргэхэд оршино.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

-  Дулаан үйлдвэрлэл
-  Цэвэр усны төвлөрсөн хангамж
-  Цэвэрлэх байгууламж

Үйл ажиллагааны дэд чиглэл:

-  Халуун ус
-  Ус түгээх 4 худаг
-  Автомат худаг
-  Хог тээвэр
-  Гэрэлтүүлэг
-  Зам, талбайн арчилгаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Ахмадийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд си ти эс программ хангамж ашигладаг байна.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг "бага" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 359,328.7 мянган төгрөгөөс тооцон 3,593.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт орлогын 6,528,521.6 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 9969,84 мянган төгрөгөөр тогтоосон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4 336 900,98 мянган төгрөгөөр буюу байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,243.9	16,035.5	0
Авлага	26565.6	28,720.2	2154,6
Урьдчилгаа		14080.0	
Бараа материал	59490,5	51487,7	8002,8
Үндсэн хөрөнгө	4,248,600.8	4,227,958.8	20642,0
Нийт хөрөнгө	4,336,900.9	4,338,482.3	-1581,4
Өр төлбөр	8,943.5	3,567.8	5,375.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,405,291.8	4,405,291.8	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,336,899.9	4,338,481.3	-1581.4

Бараа материалын дансны үлдэгдэл 51,487.7 мянган төгрөгөөр бараа материал үлдсэн байна.

Тайлант онд бие бус хөрөнгөд өөрчлөлт буюу өсөлт, бууралт ороогүй байна.

Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны авлагын данс эхний үлдэгдэл 17,233,1 мянган төгрөг байсан ба үйл ажиллагааны явцад үндсэн үйл ажиллагаатай холбоотой 18,260.3 мянган төгрөгийн авлага үүсэж 18260,3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Хутаг-Өндөр сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд 701,115.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 701,156.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.


Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/


УС ТҮГЭЭХ 4 ХУДГИЙН ОРЛОГО




ХОГ ХАЯГДАЛ АЧИЛТЫН ОРЛОГО



ХАЛУУН УСНЫ ОРЛОГО



ЦЭВЭР, БОХИР УСНЫ ОРЛОГО



ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2019 оны 2-р сарын 14-ний 10 тоот тогтоолоор “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын 2019 оны төсөв, төлөвлөгөөг баталсан.

2019 оны үйл ажиллагааны орлого, өртөг, зардлын төсвийг төрөл тус бүрээр дэлгэрэнгүй гаргаж, нийт 7 хавсралтаар төсөв батлагдсан.

Сумын ИТХ-ын ээлжит 8-р хуралдаанд “Илчит Хутаг” ОНӨҮГ-ын 2018 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг танилцуулж, “хангалттай” гэж дүгнэсэн.

Нийт зардлын 498,492.1 мянган төгрөгийг өөрийн орлого, 0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,353.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн алдааг залруулж, 144.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 8,319.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 890,15 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өглөө.

Аудитаар дараах 9,353.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 144.0 мянган төгрөгийн төлбөр барагдуулах акт, 8,319.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлангийн хугацааны эцэст нийт 8 319.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байх бөгөөд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 -т заасанчлан Ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргийнхээ дагуу дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж байх.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлагаар хүргүүлээ.

2. Тайлангийн хугацаанд байгууллагын даргын тушаалаар 5 ажилтанд сахилгын шийтгэлийн арга хэмжээ авсан боловч бүтээмжийн /үр дүнгийн/ урамшуулал 144.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ зөрчил Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар бүлгийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх заалт "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно" мөн хөдөлмөрийн тухай хуулийн 49.1 ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно" гэсэн заалтуудыг үндэслэн Байгууллагын дотоод журамд сахилгын шийтгэлтэй ажилтанд 6 сар урамшуулал олгохгүй гэсэн заалтын дагуу тооцож байх.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн актаар хүргүүлээ.

Аудитаар илэрсэн 890,15 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаж үзэх.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн данстай холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн тайлагнасан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:

Аудитор

Д.Мягмарсүрэн

Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Огноо

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
2	Мөнгөн хөрөнгө	2,243,985.70	16,035,509.11
37	Нийт хөрөнгө	4,336,900,985.42	4,338,482,340.31
52	Өр төлбөр эзний өмч	4,336,899,984.64	4,338,481,339.53

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны орлого	0	498,492,158.49
2	Үйл ажиллагааны зардал	0	380,782,846.28

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны орлогын дүн		551,804,119.00
17	Нийт зарлага цэвэр зээл		551,804,119.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019.12.31	4,405,291,861.00		92,664,621.4	4,338,481,339.53
2019.12.31	4,405,291,861.00		92,664,621.4	4,338,481,339.53